



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

---

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

Аудитын код: ГСА-2018/49/СТА-ТШЗ

**СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН  
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

(2017 оны 12 дугаар сарын 31-нээр  
дуусвар болсон)

2018.02.24



# АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дарваа хаягаар харилцана уу:

ТАБ-ын Дарга, Тэргүүлэх аудитор  
Б.Сарантуяа  
Утас: 70543156  
Цахим хаяг: [sarantuyab@audit.gov.mn](mailto:sarantuyab@audit.gov.mn)

Аудитын менежер Г.Наранбаяр  
Утас: 70543179  
Цахим хаяг: [naranbayarg@audit.gov.mn](mailto:naranbayarg@audit.gov.mn)

Аудитор М.Ундармаа  
Утас: 70543151  
Цахим хаяг: [undarmaam@audit.gov.mn](mailto:undarmaam@audit.gov.mn)

Хаяг: ГСА, Сүмбэр сум 3-р баг, Нутгийн  
удирдлагын ордон 2 давхар

## Аудитын тайлан

### Агуулга

1. Аудитын гэрчилгээ
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Төсвийн гүйцэтгэлийн тайлан
4. Менежментийн захидал

Аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан .....	3
2.1	Оршил.....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	3
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	8
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.....	9
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.....	9
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.....	9
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.....	9
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.12	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	11
3	Менежментийн захидал .....	12
3.1	13	
3.2	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
3.3	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15
3.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
3.5	Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
3.6	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	19



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: goviumber@audit.gov.mn

АЙМГИЙН СТАТИСТИКИЙН  
ХЭЛТСИЙН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  
Л.МӨНГӨНЦЭЦЭГ ТАНАА

2018.08.24 № ГИА-2018/49/СТА-ТМБ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлэгдсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус хэлтэст мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

80050

## **2 АУДИТЫН ТАЙЛАН**

### **2.1 Оршил**

Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны санхүүгийн аудитын тайланг төсвийн захирагч Л.Мөнгөнцэцэгт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг "Менежментийн захидал"-д тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018.01.31-нээс 2018.02.22-ны хооронд хийж, аудитын тайланг 2018.02.23-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, аудитор М.Ундармаа хариуцаж хэрэгжүүлэв.

Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа төрийн аудитын байгууллагад 2018.01.22-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтгласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс" нь "Улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн талаархи шинжлэх ухааны арга зүйгээр тооцсон, статистикийн үнэн бодит мэдээлэл, судалгаагаар төр, засаг, иргэн байгууллагад адил тэгш үйлчлэхэд оршино" гэсэн эрхэм зорилгын дор Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс" нь дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

- Улсын бүртгэлд суурилсан хүн ам, өрх, бизнес регистрийн санг шинэчлэн байгуулж, төрийн нэгдсэн сүлжээнд холбох, статистикийн салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулж мэдээлэл цуглуулах, боловсруулах, тархаах үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг өргөн ашиглах
- Орон нутгийн хэрэгцээнд суурилсан статистикийн үзүүлэлтийн хүрээг тодорхойлж арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх
- Статистикийн боловсрол, хэрэглээний үр өгөөжийг дээшлүүлэх
- Салбарын ажиллагсдын цалин урамшууллын оновчтой системийг бий болгож нийгмийн асуудалд бодитой дэмжлэг үзүүлэх

- Статистикийн албаны 90 жилийн ойн хүрээнд Монгол улсын статистикийн хөгжлийн түүхэн замнал, хүрсэн түвшин, олон улсад эзлэх байр суурь, оролцоог илтгэсэн бүтээлч ажил өрнүүлэх

Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- МУ-ын ЗГ-ын тогтоол, журам
- Нийгмийн даатгалын хууль
- Хувь хүний орлогын албан татварын хууль
- Статистикийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Төрийн нууцын тухай хууль
- Хувь хүний нууцын тухай хууль
- Байгууллагын нууцын тухай хууль
- Архивын тухай хууль
- Хүн ам, орон сууцны тооллогын тухай хууль
- Авилагын эсрэг хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

#### **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны А/11 дүгээр тушаалаар Үндэсний статистикийн салбар системийн хэмжээнд мөрдөж ажиллах НБББББ-ийг шинэчлэн баталж мөрдөж ажиллаж байна.

Аудитын явцад судалсан дотоод хяналтаар санхүүгийн тайланг зөрүүтэй тайлагнадаг зөрчил илэрсэн бөгөөд шат шатны хяналтыг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 2 буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн "Санхүүгийн тооцоолох" компанийн "ACOLUS" програм хангамжийг 2015 оноос ашиглаж, 2 удаа шинэчлэл хийсэн байна.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 18 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 2 асуудал эрсдэл өндөр, 6 асуудал эрсдэл дунд, гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 24 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 2 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгов.

Аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого нийт орлогод нэмэгдэж тооцогдсон, нийт хөрөнгийн дүн бага байгаа тул байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 75,022.1 мянган төгрөг бөгөөд түүний 1% буюу 750.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1%-иар тооцсон нь өмнөх жилүүдийн аудитаас зөрчилгүй дүгнэлт авч байсантай холбоотой юм.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр 11 эрсдэлтэй асуудалд 11 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 44 хувь буюу 4 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	(мянган төгрөгөөр)		
		Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	0	0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сэхилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	0	0	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний тайланд 7,066.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын сангаас олгосон жирэмсэн амаржсаны тэтгэмжийг орлого, зарлагаар тайлагнасан.

Энэ нь НББ-ын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.9 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Аудитын явцад залруулав.

2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд цалингийн зардлыг 20.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

Энэ нь НББ-ын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.9 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Аудитын явцад залруулав.

3. Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланд зардал санхүүжүүлэх 17,376.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг тайлагнаагүй.

Энэ нь НББ-ын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.9 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Аудитын явцад залруулав.

4. Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланд 3,533.4 мянган төгрөгийн залруулгын дүнг зардлаар тайлагнасан.

Энэ нь НББ-ын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.9 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Аудитын явцад залруулав.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

- 2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.
- 2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.
- 2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.
- 2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.

Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 27,996.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа.

## 2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн шатанд авч үзэх асуудал байхгүй болно.

## 2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 53,515.5 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	53,515.5	53,482.0	-0.06%	-33.4
1.1	Урсгал зардал	53,515.5	53,482.0	-0.06%	-33.4
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
2	Зардлыг сахуужуулах эх үүсвэр				
2.1	Улсын төсвөөс санхүүжих				
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос				

Тайлант онд 52,315.5 мянган төгрөгний төсөв батлагдсанаас төсвийн тодотголоор 1,200.0 мянган төгрөг нэмэгдэж, 53,515.5 мянган төгрөгийн санхүүжилт

авч, 53,482.0 мянган төгрөг зарцуулж, цалингийн зардлаас 33.4 мянган төгрөгийн хэмнэлтийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Мөн дээд шатны төсвийн байгууллагаас 13,819.1 мянга, аймгийн засаг даргын А/316 тоот захирамжаар жилийн эцсийн хүн, мал, хөдөө аж ахуй, тэжээвэр амьтдын 2017 оны жилийн эцсийн тооллого, цэрэг, техникийн шинэчилсэн тоо бүртгэлд 3,557.0 мянга, нийт 17,376.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж зарцуулсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайланд санхүүжилт 53,515.5 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 17,376.1 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 831.0 мянга, нийт 71,722.6 мянган төгрөгийн орлогыг бүртгэж тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайлангаар санхүүжилт 53,515.5 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 17,376.1 мянга, нийт 70,891.6 мянган төгрөгийн орлогыг бүртгэсэн байна.

Тайлант хугацаанд 1,109.1 мянган төгрөгийн бараа материалын эхний үлдэгдэлтэй байсан ба төсвийн хөрөнгөөр 9,265.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 8,967.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 1,407.6 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

2017 онд санхүүгийн тайланд НДШ, ХАОАТ-ийн өглөгийн 1,016.2 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй, өглөгийн эцсийн үлдэгдэлгүй, авлагын эхний болон эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Тайлант онд Үндэсний Статистикийн хорооноос нийт 831.0 мянган төгрөгийн 2 принтер үнэ төлбөргүй хүлээн авч, машин тоног төхөөрөмжийн дансанд тусгасан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

## **2.12 Шилэн дансны мэдээлэл**

Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 11 эрсдэлтэй асуудал тогтоогдож, 11 горим сорил хэрэгжүүлэв.

Тус хэлтэс нь Шилэн дансны хуулийн дагуу нийт 149 мэдээлэл оруулахаас 1 мэдээллийг оруулах хугацаа болоогүй, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг огт оруулаагүй, 146 мэдээллийг оруулсан байна.

### **2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй.

### **2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж "Зөрчилгүй" санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Говьсүмбэр аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

**Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.**

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг мэдэгдье.

### 3.1 НББ-ийн дансны бичилтийн талаар

#### Илрүүлэлт

Тайлант хугацаанд НББ-ийн дансны бичилтийг буруу хийснээс 27,996.1 мянган төгрөгийн алдааг тайланд залруулсан байна.

#### Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь НББ-ийн тухай хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах

#### Хариуцах ажилтан

Нягтлан бодогч С.Ууганцэцэг

#### Эрсдэл

Санхүүгийн тайлан хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байх эрсдэлтэй.

#### Төсвийн захирагчийн хариу

Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.2 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,109,154.00</b>	<b>1,407,654.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,109,154.00	1,407,654.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	1,109,154.00	1,407,654.00
35410	Бичиг хэргийн материал		262,500.00
35420	Аж ахуйн материал	1,109,154.00	1,145,154.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,105,065.58</b>	<b>4,024,231.36</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,105,065.58	4,024,231.36
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	5,105,065.58	4,024,231.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	25,499,973.00	26,330,973.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,177,318.45)	(22,882,888.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,548,700.00	2,548,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,766,288.97)	(1,972,553.37)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=II</b>	<b>6,214,219.58</b>	<b>5,431,885.36</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,016,270.00</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,016,270.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,016,270.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,016,270.00	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,197,949.58</b>	<b>5,431,885.56</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	5,197,949.58	5,431,885.56
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	5,197,949.58	5,431,885.56
51210	Өмнөх үеийн үр дүн	5,197,949.58	5,197,949.78
51220	Тайлант үеийн үр дүн		233,935.78
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>6,214,219.58</b>	<b>5,431,885.56</b>

Аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

3.3 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	29,377,680.00	75,256,115.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	831,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	831,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	831,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		831,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	29,377,680.00	74,425,115.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	17,569,600.00	53,515,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	17,569,600.00	53,515,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,808,080.00	20,909,615.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,874,200.00	3,557,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,933,880.00	17,352,615.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	31,481,008.34	75,022,179.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,481,008.34	75,022,179.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,388,508.34	73,260,683.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,662,511.00	41,422,815.00
210101	Үндсэн цалин	15,662,511.00	41,422,815.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,816,185.00	4,827,029.00
210201	Тэтгэврийн даатгал	1,163,611.00	3,135,465.00
210202	Тэтгэмжийн даатгал	132,981.00	381,196.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	162,344.00	395,574.00
210204	Ажилгүйдлийн даатгал	32,478.00	83,161.00
210205	Эрүүл мэндийн даатгал	324,771.00	831,633.00
2104	Хангамж, бараа материалын зардал	685,500.00	1,749,000.00
210401	Бичиг хэрэг	135,317.00	308,300.00
210402	Тээвэр, шатахуун	255,500.00	632,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	294,683.00	592,300.00
210408	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		216,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	95,000.00
210604	Урсгал засвар		95,000.00
2107	Томилолт, зочны зардал	111,000.00	375,000.00
210702	Дотоод албан томилолт	111,000.00	375,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,787,900.00	22,335,505.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,787,900.00	21,500,305.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		835,200.00



Аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,325,412.34	2,456,334.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	229,200.00	544,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,096,212.34	1,911,834.22
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	92,500.00	1,781,496.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	1,728,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,728,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	92,500.00	33,496.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	92,500.00	33,496.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(2,103,328.34)</b>	<b>233,935.78</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(2,103,328.34)</b>	<b>233,935.78</b>

Аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

3.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>29,678,600.00</b>	<b>70,891,658.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>29,678,600.00</b>	<b>70,891,658.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	17,569,600.00	53,515,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	17,569,600.00	53,515,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	12,109,000.00	17,376,158.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,874,200.00	3,557,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,234,800.00	13,819,158.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>29,678,600.00</b>	<b>70,891,658.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>29,678,600.00</b>	<b>70,891,658.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>29,586,100.00</b>	<b>69,130,162.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	14,821,100.00	42,531,604.00
210101	Үндсэн цалин	14,286,100.00	27,725,304.00
210102	Нэмэгдэл		5,171,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	285,000.00	1,437,500.00
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс	250,000.00	8,197,200.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	1,630,300.00	4,681,700.00
210201	Тэтгэврийн даатгал	1,630,300.00	2,989,641.00
210202	Тэтгэмжийн даатгал		339,853.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		437,415.00
210204	Ажилгүйдлийн даатгал		83,160.00
210205	Эрүүл мэндийн даатгал		831,631.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	685,500.00	1,813,500.00
210401	Бичиг хэрэг	135,317.00	336,800.00
210402	Тээвэр, шатахуун	255,500.00	632,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	294,683.00	592,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		252,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	95,000.00
210604	Урсгал засвар		95,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	111,000.00	375,000.00
210702	Дотоод албан томилолт	111,000.00	375,000.00

Аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	12,109,000.00	19,088,858.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,109,000.00	18,019,658.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		1,069,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	229,200.00	544,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	229,200.00	544,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>92,500.00</b>	<b>1,761,496.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	1,728,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,728,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	92,500.00	33,496.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	92,500.00	33,496.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	±	±
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-

Аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

3.5 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгэний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	5,197,949.58	0.00	5,197,949.58
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	5,197,949.58	0.00	5,197,949.58
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			233,935.78		233,935.78
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	5,431,885.36	0.00	5,431,885.36

3.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	53,515,500.00	53,482,004.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	53,515,500.00	53,482,004.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,787,500.00	51,754,004.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	42,561,400.00	42,531,604.00

Аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

210101	Үндсэн цалин	27,755,100.00	27,725,304.00
210102	Нэмэгдэл	5,171,600.00	5,171,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,437,500.00	1,437,500.00
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс	8,197,200.00	8,197,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>4,681,700.00</b>	<b>4,681,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	3,097,172.00	2,989,641.00
210202	Тэтгэмжийн даатгал	381,786.00	339,853.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	331,182.00	437,415.00
210204	Ажилгүйдлийн даатгал	79,196.00	83,160.00
210205	Эрүүл мэндийн даатгал	792,364.00	831,631.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,813,500.00</b>	<b>1,813,500.00</b>
210401	Бичиг хэрэг	320,800.00	336,800.00
210402	Тээвэр, шатахуун	632,000.00	632,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	608,300.00	592,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	252,400.00	252,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>95,000.00</b>	<b>95,000.00</b>
210604	Урсгал засвар	95,000.00	95,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>378,700.00</b>	<b>375,000.00</b>
210702	Дотоод албан томиллолт	378,700.00	375,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,712,700.00</b>	<b>1,712,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	643,500.00	643,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,069,200.00	1,069,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>544,500.00</b>	<b>544,500.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	544,500.00	544,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,728,000.00</b>	<b>1,728,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,728,000.00</b>	<b>1,728,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,728,000.00	1,728,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>53,515,500.00</b>	<b>53,515,500.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>53,515,500.00</b>	<b>53,515,500.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	53,515,500.00	53,515,500.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>4.00</b>	<b>4.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	2.00	2.00

Аймгийн "Статистикийн хэлтэс"-ийн 2017 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

620003	Үйлчлэх ажилтан	-	-
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00